

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 12 дугаар сарын 03-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-1
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	2-3

1.Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	2-3
---	-----

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 12 дугаар сарын 03-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 06 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Р.Батболд, Ж.Ганбаатар, Г.Ганбаатар, П.Ганзориг, Х.Ганхуяг, Б.Мөнхсоёл, П.Мөнхтулга, З.Мэндсайхан, Д.Пүрэвдаваа, Б.Түвшин.

Нэг.Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Солонгоо, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, мөн албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 09 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 04 минут үргэлжилж, 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр 13 цаг 10 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ц.ДАВААСҮРЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 12 дугаар сарын 03-ны өдөр, Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим,
13 цаг 06 минут

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Даваасүрэн: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг эрье. Байнгын хорооны хуралдаанд ирэх ёстой 25 гишүүнээс 14 гишүүн ирж, ирц 56 хувьтай байна. Би ирсэн гишүүдийг танилцуулъя.

Телеуханы Аубакир гишүүн, Дамбын Батлут гишүүн, Хөххүүгийн Болормаа гишүүн, Гонгорын Дамдинням гишүүн, Даваагийн Цогтбаатар гишүүн, Далайн Батбаяр гишүүн, Батмөнхийн Батцэцэг гишүүн, Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн, Батжаргалын Заяабал гишүүн, Баттогтохын Чойжилсүрэн гишүүн, Жигжидийн Батжаргал гишүүн, Жадамбаагийн Баясгалан гишүүн, Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн, Ганзоригийн Тэмүүлэн гишүүн нар хуралдаанд оролцож байна.

2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн Төсвийн байнгын хорооны хуралдааны ирц 56 хувьтай байгаа учраас хуралдааныг нээснийг мэдэгдье.

Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя.

Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг. Хэлэлцэх асуудал дээр саналтай, асуулттай гишүүн байна уу.

Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг эхлүүлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Болдын Жавхлан Сангийн сайд, Баярсайханы Солонгоо Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга, Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга гэсэн ийм бүрэлдэхүүнээр оролцож байна.

Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх хувилбарыг та бүхэнд тараасан байгаа. Эцсийн хувилбарын төсөлтэй холбогдуулаад асуух асуулттай гишүүн байна уу. Алга байна.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Аубакир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна.

Төвсийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Өнөөдрийн хуралдаан үүгээр дууслаа. Баярлалаа гишүүд дээ.

13.10 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ